



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
<http://www.mojha.gov.mn>

2019.01.24 № 1-1/384
танай _____-ны № _____-т

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЙД Ч.УЛААН ТАНАА**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн “Монгол Улсын 2019 онд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр, төрөл, тоо хэмжээг тогтоох тухай” А-20 дугаар тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзэж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн ...~~4.17А~~... дугаарт бүртгэснийг үүгээр мэдэгдье.



Ц.НЯМДОРЖ

151600233
Doc.yam as 2019



Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019 оны 01 сарын 23-ны өдрийн 4172 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А-20

Улаанбаатар хот

“Монгол Улсын 2019 онд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр, төрөл, тоо хэмжээг тогтоох тухай

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэг, Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааны 01 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-д үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтад нийцүүлэн 2019 онд экспортлох стратегийн хүнсний нэр, төрөл, тоо хэмжээг 1 дүгээр, импортлох стратегийн хүнсний нэр, төрөл, тоо хэмжээг 2 дугаар хавсралтад заасны дагуу тус тус тогтоосугай.

2. Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журам”-ын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэг /Т.Гантогтох/-т, зөвшөөрлийг хууль, тогтоомж, энэхүү тушаалд нийцүүлэн олгож ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргад тус тус даалгасугай.

3. Тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг Хуулийн хэлтэс /Э.Цолмонжаргал/-т үүрэг болгосугай.

САЙД  Ч.УЛААН

Бүртгэл нөх дугаар 18
МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
Хуульбар олгосон ажилтны гарын үсэг

2019 оны 01 сарын 18-ны өдөр

00000055

Хүнс, хөдөө аж ахуйн
хөнгөн үйлдвэрийн Сайрын
2019 оны 01 дугаар сарын 18-ны
өдрийн 01 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

2019 ОНД ЭКСПОРТЛОХ СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ НЭР ТӨРӨЛ,
ТОО ХЭМЖЭЭ, АНГИЛЛЫН КОД

№	Стратегийн хүнсний нэр	Төрөл	БТКУС-ын код	Нийт тоо, хэмжээ
1	Үхрийн мах	Үхрийн гулууз болон өрөөл шинэ эсхүл хөргөсөн мах	0201.10.00	29900 тн (хорин есөн мянга есөн зуу)
2		Үхрийн ястай нь хэсэглэсэн шинэ эсхүл хөргөсөн мах	0201.20.10	
3		Үхрийн ясгүй хэсэглэсэн, шинэ эсхүл хөргөсөн мах	0201.30.10	
4		Үхрийн гулууз болон өрөөл, хөлдүү мах	0202.10.00	
5		Үхрийн ястай нь хэсэглэсэн, хөлдүү мах	0202.20.10	
6		Үхрийн ясгүй хөлдүү мах	0202.30.10	
7		Сарлагийн ястай нь хэсэглэсэн шинэ эсхүл хөргөсөн мах	0201.20.20	
8		Сарлагийн ясгүй шинэ эсхүл хөргөсөн мах	0201.30.20	
9		Сарлагийн ястай хөлдүү мах	0202.20.20	
10		Сарлагийн ясгүй хөлдүү мах	0202.30.20	
11	Адууны мах	Адууны ястай шинэ, хөргөсөн, хөлдүү мах	0205.00.11	31000 тн (гучин нэгэн мянга)
12		Адууны ясгүй (шулсан) шинэ, хөргөсөн, хөлдүү мах	0205.00.12	

Бүртгэлийн дугаар ... 18 ...
МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар тусгаж ажилтны гарын д.
Т. Мэгамжа
2019 оны 01 сарын 18-ны өдөр

Хүнс, хөдөө аж ахуй,
хөнгөн үйлдвэрийн сайдын
2019 оны 01 дугаар сарын 20-ны
өдрийн 01 дугаар тушаалын
2 дугаар хавсралт

2019 ОНД ИМПОРТЛОХ СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ НЭР ТӨРӨЛ,
ТОО ХЭМЖЭЭ, АНГИЛЛЫН КОД

№	Стратегийн хүнсний нэр	Төрөл	БТКУС-ын код	Нийт тоо, хэмжээ
1	Үхрийн мах	Үхрийн гулууз болон өрөөл шинэ эсхүл хөргөсөн мах	0201.10.00	500 тн (таван зуу)
2		Үхрийн ястай нь хэсэглэсэн шинэ эсхүл хөргөсөн мах	0201.20.10	
3		Үхрийн ясгүй хэсэглэсэн, шинэ эсхүл хөргөсөн мах	0201.30.10	
4		Үхрийн гулууз болон өрөөл, хөлдүү мах	0202.10.00	
5		Үхрийн ястай нь хэсэглэсэн, хөлдүү мах	0202.20.10	
6		Үхрийн ясгүй хөлдүү мах	0202.30.10	
7	Хуурай сүү	Хуурай сүү	0402.21.10	6000 тн (зургаан мянга)
8	Улаанбуудайн гурил	Улаанбуудай-хөх тарианы гурил (меслин)	1101.00.20	1000 тн (нэг мянга)
9		Дээд гурил	1101.00.11	11000 тн (арван нэгэн мянга)
		Нэгдүгээр гурил	1101.00.12	
		Хоёрдугаар гурил	1101.00.13	
10	Шингэн сүү	Жингийн 1%-иас ихгүй хэсэгт тослог агуулсан	0401.10.00	720 тн (долоон зуун хорь)
		Жингийн 1%-иас их боловч 6%-иас ихгүй хэсэгт тослог агуулсан	0401.10.20	
		Жингийн 1%-иас их боловч 10%-иас ихгүй хэсэгт тослог агуулсан	0401.10.40	
		Жингийн 10%-иас их хэсэгт тослог агуулсан	0401.10.50	
11	Үрийн улаанбуудай	Үрийн хатуу улаанбуудай	1001.11.00	10000 тн (арван мянга)
12		Үрийн зөөлөн улаанбуудай	1001.91.10	

Бүртгэлийн дугаар 18
МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
Хуульбар өдгөө аж ахуйн үсэг
2019 оны 01 18